



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/78

Баянбулаг

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
яаралтай дархлаажуулалтын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Улсын онцгой комиссын 2022 оны 03 дугаар сарын 23 –ны өдрийн 02 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/191 дүгээр тушаал, Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Малын шилжилт хөдөлгөөнийг хориглох тухай” А/21 дугаар захирамж, 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/585 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд сумын хэмжээнд статистик мал тооллогоор тоологдсон 1183 үхэр, 544 тугал нийт 1727 толгой үхрийг хамруулан чанартай зохион байгуулахыг “БЭЭЭЭГ”- Мал эмнэлгийн их эмч Д.Эрдэнэсүвд, “Дэлгэрэх баян сав” мал эмнэлгийн их эмч Ю.Гаамаа нарт даалгасугай.

2. Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын зарыг малчдад хүргэж мал сүргийг товросон хугацаанд бэлэн байлгаж барьж, бэхлэх малын эмчийн аюулгүй байдлыг хангуулан ажиллахыг Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын явцад өдөр тутам хяналт тавьж вакцины дархлаа тогтох 28 хоногийн хугацаанд малчдын нүүдэл, малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байхыг малчдад зөвлөн ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Б.Батхонгор)-д, сумын хэсгийн цагдаа (Б.Лувсандорж)-нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтын ажил хийж гүйцэтгэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

5. Вакцинжуулалтын шатахууны үнэ болох 813,500 (Найман зуун арван гурван мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Нягтлан бодогч Г.Түмэнболд-д зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч Б.Амгаланбаатар-т даалгасугай.

ДАРГА  Н.ГАНСҮХ



642201081

2022 on zahiramj

Баянцагаан сумын Засаг даргын *2008* оны *09* сарын  
*15* өдрийн *А/78* дугаар захирамжийн хавсралт



ЗОХИОН БАЙГУУЛЖ, ХЯНАЛТ ТАВИХ  
АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч Б.Батхонгор (Мал эмнэлгийн тасгийн улсын  
байцаагч, Тасгийн дарга)

Гишүүдэд Ш.Батболд (Гичгэнэ 1-дүгээр багийн Засаг дарга)

Ж.Уламбадрах (Дэлгэрэх 2-дугаар багийн Засаг дарга)

Б.Цэрэнпунцаг (Цэцэн 3-дугаар багийн Засаг дарга)

Д.Ариунаа (Жаргалант 4-дүгээр багийн Засаг дарга)

Г.Өлзий-орших (Баянбулаг 5- дугаар багийн Засаг дарга)

Д.Эрдэнэсүвд (БЭЭЭЭГ-Мал эмнэлгийн эрхлэгч, их эмч)

Ю.Гаамаа (Дэлгэрэх баян сав мал эмнэлгийн эрхлэгч, их эмч)

Э.Энхбаяр (Санитарч)

Б.Цэрэндорж (Туслах ажилтан)

-----oOo-----